

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
218 дугаар тогтоолын 46 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

2025.05.21

Байгууллагын нэр:

Эрүүл мэндийн яам

Нэгжийн нэр:

Санхүү, эдийн засгийн бодлогын газар,
Хөрөнгө оруулалтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын
бодлого, хэрэгжилт хариуцсан
мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII
дугаар байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Гадаад, дотоодын зээл тусламжийн хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжилт, төсөл хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлт, бодлого, хэрэгжүүлэх, зохицуулах;
2. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн цахим систем болон судалгаа, үйл ажиллагааг зохицуулах;
3. Салбарын санхүүгийн нэгдсэн тайланд зээл, тусламжаар хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн мэдээ, мэдээллийг нэгтгүүлэх, тайлагнах;
4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлт, бодлого, хэрэгжилт, зохицуулалт хийх;	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлж, төлөвлөлт хийнэ.	Г
	2. Салбарын тухайн жилийн зээл тусламжийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсруулах, батлуулах;	Зээл тусламжийн төлөвлөлтийг боловсруулж, батлуулсан байна.	Г
	3. Зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөрийн техникийн нөхцөлийн үнэлгээ хийх үйл ажиллагааны зохицуулалт хийх.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Х, Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Эрүүл мэндийн салбарын зээл тусламжийн хэрэгцээг тодорхойлж, дүн шинжилгээ, судалгаа хийх, мэдээний сан үүсгэх;	Судалгаа шинжилгээ хийгдэж, мэдээний сан үүссэн байна	Г
	2. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн цахим системийн үйл ажиллагааны зохицуулалт хийх.	Цахим системийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Г
3 дүгээр зорилтын хүрээнд	1. Салбарын санхүүгийн нэгдсэн тайланд зээл, тусламжаар хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн мэдээ, мэдээллийг нэгтгүүлэх, тайлагнах;	Журмын дагуу тайлагнасан байна	Г

	2. Төсөл, хөтөлбөрийн тайлан мэдээг тухай бүр тайлагнах, холбогдох байгууллагад хүргүүлэх;	Журмын дагуу тайлагнасан байна.	Г
	3. Эрүүл мэндийн сайдын багцын гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн шилэн дансны үйл ажиллагааг тайлагнах, хяналт тавих;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Хариуцсан асуудлын хүрээнд яамны болон төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Нэгжийн тайлан, мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргасан эсэхэд хяналт тавьж, дүгнэсэн байна.	Г
	2. Хариуцсан асуудлаарх эрсдэлийн шалгуур үзүүлэлт боловсруулах, батлуулах	Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж батлуулсан байна.	Г
	3. Хариуцсан асуудлын хүрээнд ирсэн албан бичиг, өргөдөл, хүсэлтийг судалж, шийдвэрлэх, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж бүрдүүлж, хүлээлгэн өгөх;	Шийдвэрлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн, албан хэргийн стандартын дагуу хөтөлсөн байна.	Ш, Г
	4.Төрийн аудитын байгууллагаас хөрөнгө оруулалтад гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжилтэд хяналт тавих, нэгтгэн тайлагнах;	Аудитын зөвлөмжийг хэрэгжилтийн хангасан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	- эдийн засагч /0311/; - санхүү /0412/; - эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер /078810/.	
Мэргэшил		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
	Дүн шинжилгээ хийх	- тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах, харьцуулан судлах; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - бусад.

	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаврыг хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх - ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах - багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - бусад.
	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - англи хэл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Санхүү, эдийн засгийн бодлогын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

-

Бусад харилцах субъект


- Засгийн газрын хэрэг эрхлэх газар, яам, агентлаг, бусад төрийн байгууллагын

	газар, хэлтэс, нэгжийн холбогдох албан хаагч; - Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллагын ажилтан; - Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан, иргэн.
--	---

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА /Б.БАТБАЯР / 2025 оны .. дугаар сарын -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 25 05 21 <u>Дугаар:</u> 218

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

<u>Байгууллагын нэр:</u> ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u> (тамга/тэмдэг) ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА 2025 оны ... дугаар сарын -ны өдөр	 /Д.ОЧИРБАТ/
--	--